

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-14
1. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	5-14

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 03 дугаар сарын 18-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 43 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Д.Ганбат, Б.Заяабал, Л.Мөнхбаатар,
У.Отгонбаяр, П.Сайнзориг;
Эмнэлгийн чөлөөтэй: Да.Цогтбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Сандаг-Очир танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Э.Бат-Амгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 38 минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 12 цаг 43 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Завшааныг ашиглаад энд оролцож байгаа гишүүддээ эрэгтэй нь ч, эмэгтэй нь ч бүгдэд нь бас Монгол цэргийн баярын мэндийг хүргэе. Эмэгтэйчүүддээ Мартын 8-ны мэндийг давхцуулаад бас хүргэчихье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Энхтайвангийн Бат-Амгалан, Халтмаагийн Баттулга, Хүрэлбаатарын Баасанжаргал, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд ирснээр, 54,5 хувийн ирцтэйгээр ирцийн шаардлага хангагдсан байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 1 асуудал хэлэлцэхээр байгаа. Хэлэлцэх асуудал бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлт байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Хэлэлцэх асуудалтай холбоотой 1 санал байна. Гэхдээ яах вэ, нөгөө Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудалд албан ёсоор ороогүй ч гэсэн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор яаралтай учраас энэ асуудлыг хэлэлцэх боломжтой эсэхийг бас тодруулж байгаа гэсэн үг.

Би сая Байнгын хорооны хурлаас өмнө чатаар бас асуусан. Одоо яг энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэх гэж байгаа энэ цаг үед одоо болж байгаа энэ Noorog.mn гээд байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн холбогдох залуучуудтай холбоотой энэ баривчлах, хойшлуулшгүй гэдэг ажиллагаагаар энэ ажиллагааг хийсэн гэж одоогийн байдлаар бол ойлгож байна. Тэгэхээр үүнтэй холбоотой нэгэнт манай Байнгын хорооны эрхлэх асуудал бол хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өмгөөллийн асуудалд ингээд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагааны гүйцэтгэл, мөрдөн байцаалтын ажиллагааны асуудал гээд ийм асуудлууд байдаг.

Тэгээд хэдийгээр энэ хэрэг дээр прокурор хяналт тавьж байгаа ч гэсэндээ бид нар тухайн хэргийнх нь тухай асуух гээгүй. Хэргийн процесс ажиллагаа нь

өөрөө хүний эрхэд нийцэж байгаа эсэх талаар ийм мэдээллийг бол яаралтай холбогдох эрх бүхий албан тушаалтнуудаас авах ийм саналтай байна. Тэгээд энийг яг албан ёсны Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудалд оруулж болох уу гэж асуух гэсэн юм.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн ээ, өөрийн чинь ярьж байгаа, сэтгэл зовниж байгаа бол зөв. Энд байгаа бүх гишүүд энэ мэдээллийг авчихсан бас сэтгэл нь зовниж байгаа. Өөрийн чинь энэ чат дээр тавьсны дагуу хэлэлцэх асуудалд оруулах гэхээр нөгөө даргын дэргэдэх зөвлөл одоо бол хуралдах боломжгүй байгаа. Их Хурлын дарга яг айлчлалд явчихсан байж байгаа учраас энэ богинохон хугацаанд бид нар хуралдуулж, хэлэлцэх асуудалд албан ёсоор оруулах боломж үнэхээр гарсангүй. Цаг хугацааны хувьд. Тийм учраас би энэ дээр ямар саналтай байгаа вэ гэхээр бид нар хэлэлцэх асуудлынхаа хүрээнд асуудлаа хэлэлцчихээд, тэгээд цагдаагийн удирдлагыг албан бусаар өөрөөр хэлбэл Байнгын хорооны гишүүд энд байлцаж байгаад, тэгээд мэдээлэл авчихъя гэж байгаа. Цагдаагийн газрын удирдлагатай холбогдсон. Цагдаагийн газрын удирдлага энэ дээр бол маш нээлттэйгээр тэгье, бид нар хүрч ирээд мэдээллээ өгөхөд бэлэн байна гэсэн.

Тийм учраас өөрсдийнх нь юуны дагуу урьчихсан байж байгаа. Яг үнэн. Өөрийн чинь саяын хэлж байгаа бас зөв. Юу гэхээр энэ чинь нөгөө бид нар хөндлөнгөөс харин улс төрийн нөлөөлөл оруулах ч юм уу ийм нөхцөл байдал үүсвэл наадах чинь тэр залуустаа бүр хүндрээд явчхаж болзошгүй учраас бид нар бол энэ дээр хараа хяналтаа тавиад хажуугаас, ялангуяа Хүний эрхийн хороо өөрөө хүний эрхийн асуудал ярьж байдаг хүмүүс учраас бид нараас бол энэ хол зайтай биш. Хэзээ ч бид нар энэ дээр анхаарлаа хандуулж байх ёстой.

Тэгээд энэ удаа бол ямар ч гэсэн дуудаж авчраад, мэдээллээ бид нар сонсох ёстой. Гэхдээ энэ бол юу гэдэг юм, тогтсон практик биш шүү дээ. Нөгөө хуулийн хараат бус байдалд ялангуяа хууль хэрэгжүүлэх байгууллагуудын хараат бус байдалд нөлөөлсөн ийм нөхцөл байдал үүсгэхгүйн үүднээс албан бусаар мэдээлэл авах гэж байгаа шүү. Өөр тэгвэл санал байхгүй бол хэлэлцэх асуудлыг баталлаа.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлт.

Дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулга хийнэ. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэнээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаар гомдол өргөдлийг гаргасны дагуу Үндсэн хуулийн цэц 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа уг маргааныг хянан хэлэлцсэн бөгөөд миний бие уг хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн иргэний өргөдөл, гомдлын агуулга нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэсэн нь алдаатай гэж үзээд, энэхүү дэвшүүлэгч нь үйлийн эзэн нь бусад сонгогчдоосоо 801-ээс доошгүй гарын үсэг зуруулах шаардлагатай мэтээр заасан нь нэг мөр ойлгох боломжгүй. Үйлийн эзнийг буюу биеийн төлөөний үгээ буруу тодорхойлсон, Монгол хэлний найруулга зүйн алдаатай. Иргэд Үндсэн хуулиар хамгаалагдан баталгаажуулсан эрхээ эдлэх гэж заавал 801-ээс доошгүй иргэний гарын үсэг цуглуулах ёстой байхад, намын гишүүд дээрх гарын үсгийг цуглуулахгүй намын сонголтоор шууд нэр дэвших эрхээ эдэлж байгаа нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй. Нам бол Төрийн бус байгууллага. Бид бүгд Монгол Улсын иргэний хувьд ижилхэн эрхтэй. Тэд Үндсэн хуульд заасан дээрх эрхээ шууд эдэлж байхад иргэн яагаад уг эрхээ эдлэх боломжгүй ялгаварлагдан гарын үсэг цуглуулах үүрэгтэй нь ойлгомжгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заасан үүргүүдэд энэ тухай огт заагаагүй. Иймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна.” 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “Төрийн байгууллагад сонгогдох эрхтэй.” гэснийг зөрчиж байгаа учир Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийг үйлчлэлийг яаралтай хүчингүй болгож өгнө үү гэсэн байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй талаарх дараах тайлбарыг гарган хүргүүлсэн. Үүнд:

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад өргөдөл гаргагч нь иргэн Д.Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг, мөн маргаан үүсгэсэн тус хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 19 дүгээр дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор өргөдлийн шаардлагаа бас нэмэгдүүлж тайлбар хийсэн болно.

Үндсэн хуулийн цэц уг маргааныг дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшигч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол олон улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн адил нэгэн адил үйлчилнэ.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” 2

дахь хэсэгт “хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.”, 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгогдох эрхтэй” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг бүрэн эхээр нь та бүхэн тараасан байгаа тул уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Бат-Амгалан гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц хүний сонгогдох Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг зөрчсөн гэх энэ үндэслэлээ гаргахдаа энэ илүү хуульчилж, журмаар зохицуулж байгаа энэ харилцаагаа илүү хуульдаа дэлгэрэнгүй нарийн болгооч гэж хууль тогтоогчид хандаж байгаа гэж ойлгож болох уу.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оролцсон хүний хувьд бол Үндсэн хуулийн цэцийн үндэслэл хэсэгт заасан үндэслэлүүдийг хуульчлах боломжтой гэж та үзэж байна уу гэсэн ийм асуулт байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүний асуулт бол хуулиар зохицуулагдаагүй зүйлийг журмаар зохицуулсан байна гэж цэцийн дүгнэлт яг ийм байдлаар гарсан байгаа. Дүгнэлтийн 1 үндэслэл нь Улсын Их Хурлын даргын өчигдрийн хаврын чуулганы нээлт дээр бас хэлсэн үгэнд хуулиас давсан журмууд бас үйлчилж байна. Журмаар зохицуулж байгаа асуудлууд олон байна. Энийг цаашдаа бас Их Хурал авч үзэх ёстой гэдэг энэ үгтэй агуулгатай нийцэж байгаа.

Тийм учраас бие даан нэр дэвшиж байгаа хүмүүс Улсын Их Хурлын сонгуульд бие даан нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн тухайн тойргийн сонгогчдын 801-ээс доошгүй иргэний гарын үсэг цуглуулж, түүнийг Сонгуулийн хороо хүлээж авч, нэгтгэж бүртгэж, хяналт тавихдаа тодорхой хуульчлаагүй журмаар зохицуулсан. Энэ нь асуудалд объектив байдлаар биш субъектив байдлаар хандаж байна.

Хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчиж байна. Агуулга нь зөв боловч түүнийг хэлбэр төдий байдлаар 801-ээс доошгүй иргэний одоо гарын үсэг нэг бүрчлэн нягталж үзэхгүй, түүврийн аргаар сонгож, энэ арга хэлбэр нь өөрөө журмаар зохицуулагдсан. Энэ журмаар хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчиж байна гэдэг ийм байдлаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бас гарсан.

Тийм учраас цаашдаа бол бас энэ хуулийн 31.2-ыг тэр журмаар зохицуулж байгаа, асуудалд бас субъектив байдлаар хандаж байгаа, эргээд энэ нь иргэний сонгогдох эрхийг зөрчиж байгаа гэж үзэж байгаа энэ асуудлыг цаашдаа бас нарийн хуульчилж, журмаар зохицуулж байгаа асуудлыг нь хуульчлах шаардлагатай юм байна гэж ингэж үзэж байгаа.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай гэж үзэж байна. Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Сандаг-Очир гишүүнээс асуулт асууя. Мэдээж дунд суудлын хуралдаан дээр маш олон асуудлууд л яригдаж, мэтгэлцэж ингэж явсан байх. Тэгээд энэ Үндсэн хуулийн дүгнэлтийг ингээд хараад байхаар зүгээр хувь хүний бодол шүү. Үндсэн эрхийг, хүний үндсэн эрхийг ер нь зөрчиж байгаа юм шиг ийм дүгнэлт гарчихсан харагдаад байгаа юм.

Нөгөө талаараа энэ Монгол Улсын Үндсэн хууль хүний тэгш эрх, үндсэн эрхийг бол нэг их зөрчиж байгаа юм бол харагдахгүй л байгаа юм шиг байгаа юм. Яагаад тэгж байна гэхээр одоо бие даан нэр дэвшиж байгаа хүн хэрвээ энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээгээд авчих юм бол цаашдаа сонгуулийн хуульд маш олон үүнтэй төстэй зүйл заалтууд байгаа шүү дээ. Жишээ нь одоо Монгол Улсын Ерөнхийлөгч 50 наснаас дээш, Улсын Их Хурлын гишүүн 25 наснаас дээш байх ёстой гээд. Тэгээд энэ зүйл заалтууд чинь бас хөндөгдөөд ирэх юм уу. Цаашдаа энэ асуудлууд бас дунд суудлын хуралдаан дээр бас яригдсан уу. Тэгэхээр энэ бас нэлээн бас бид нар анхаарч үзэж авч хариуцлагатайгаар энэ Байнгын хороо дээрээ ч яриад, Улсын Их Хуралд оруулах, оруулахгүй асуудлаар нь ярилцаад явахгүй бол үүнээс хөврөөд явдаг үр дагаврууд нь тэгээд сүүлдээ сонгуулиа ч хийж чадахгүй хэн дуртай нь нэр дэвшиж байдаг ийм л асуудал үүсэх вий дээ гэж 1 дүгээрт санаа зовж байгаа юм. Тэгэхлээр ийм асуудлууд дунд суудлын хуралдаан дээр яригдсан уу.

Ер нь тэгээд Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол мэдээж ард түмний төлөөлөл. Тэгээд тэр төлөөллөөс сонгогдох гэж байгаа бие дааж нэр дэвшиж байгаа нөхөр ямар нэгэн байдлаар тэр төлөөллөө хэрэгжүүлэх гэж байгаа тэр төлөөллийн иргэдээсээ гэдэг юм уу, сонгогчдоосоо гэдэг юм уу тодорхой хэмжээнд хариуцлага, ёс зүйтэй, итгэл үнэмшлийг авч ингэж л оролцох ёстой юм шиг санагдаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Яах вэ, ер нь бол Бат-Амгалан гишүүний асууж байгаа санал бол цэцийн дунд суудлын хуралдаан дээр нэг их яригдаагүй. Яг зөвхөн тэр 801 сонгогчийн гарын үсэг зурахтай холбоотой асуудлууд яригдсан. Зүгээр Их хурал цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа гэхэд энэ 801-ээс доошгүй гарын үсэг цуглуулах асуудал бүр ингээд огт байхгүй болчхож байгаа асуудал биш шүү. Ер нь бол цэц юу гэж үзсэн гэвэл ер нь тойргийн сонгогчдын тоотой харьцуулахад өндөр байна. Тавьж байгаа шалгуур нь, босго нь. Нэгд.

Улс төрийн намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчтэй харьцуулсан тэр харьцаа шалгуур нь бас тэгш эрхийн зарчмыг алдагдуулсан байна гэж үзэж байгаа юм. Сонгуульд оролцоход улс төрийн намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигч бол ямар нэг гарын үсэг цуглуулах асуудал байхгүй. Мэдээж улс төрийн нам бол тодорхой шалгуур шаардлагыг хангасан байх ёстой, холбогдох материалаа сонгуулийн хороонд бүрдүүлдэг. Бие дааж нэр дэвшиж байгаа субъектийн хувьд бол тойргийн сонгогчдын 801-ээс доошгүй иргэний гарын үсгийг цуглуулах ийм шалгуурыг тавьсан байгаа. Энэ нь өөрөө улс төрийн нам болоод нэр дэвшиж байгаа, бие даан нэр дэвшиж байгаа субъект 2-ын хооронд адилхан ийм

шаардлага шалгуурыг тавьж байгаа нь тэгэхээр улс төрийн нам бол Дээд шүүхэд бүртгүүлэхдээ 801-ээс доошгүй иргэний гарын үсэг цуглуулсан байдаг. Гэтэл бие даан нэр дэвшигч бол тухайн тойргийн сонгогчдын 801 гарын үсэг цуглуулж байна гэдэг бол сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш 45 хоногийн дотор 801 хүний гарын үсгийг цуглуулна гэдэг бол бас өндөр босго байна. Тэгээд 12 хоногийн хугацаанд энэ асуудлыг бүртгэж, эргээд энийг нь Сонгуулийн хороо нягталж, нэг бүрчлэн ингэж хянаж байгаа нь өөрөө бас хууль зүйн хувьд, цаг хугацааны хувьд бас боломж багатай. Энэ нь өөрөө хүн бүр хуулийн өмнө тэгш байна гэдэг энэ зарчмыг алдагдуулж байна гэж бас Цэц үзсэн байна лээ.

Тийм учраас бид нар хэрвээ Их Хурал энийг хүлээж авлаа гэж үзэхэд цаашдаа энэ нягталж байгаа 801-ээс доошгүй иргэний гарын үсгийг цуглуулсныг нягталж шалгаж үзэж байгаа Сонгуулийн хороо цаашдаа энэ хугацаанд хүн болгоныг 801-ийг хянах боломжгүй учраас субъектив байдлаар асуудалд хандаж байна. Үзэмжийн байдлаар асуудалд хандаж байна. Эргээд энэ нь өөрөө хүний сонгогдох эрхийг хязгаарласан асуудал болж байгаа учраас энэ өндөр байгаа босгыг багасгах бол боломжтой юм гэж би бол үзэж байгаа. Тийм учраас огт шалгуургүй байна гэж хэлж болохгүй. Энэ 801 гэдгийг цаашдаа бол бас бууруулаад шалгуурыг нь багасгаад, босгыг нь багасгаад ингээд явах боломжтой юм байна гэж би бол хувьдаа үзэж байгаа.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу. Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: Ер нь зүгээр яах вэ, энэ 801-ийг бол энэ дүгнэлт дээр яг тийм юу байхгүй л байна л даа. Багасгах шаардлагатай ч юм уу тийм дүгнэлт гараагүй. Ер нь зүгээр энэ гомдол гаргагчийн гаргасан гомдлыг хүлээж аваад үндэслэлтэй юм байна гээд л ингээд гарчихсан харагдаж байгаа юм. Гэхдээ нөгөө талаараа Сандаг-Очир гишүүн ч гэсэн бас улс төрийн намын төлөөлөл болж Улсын Их Хуралд сонгогдоод явж байгаа. Тэрний чинь ард энэ төлөөллийн байгууллагаараа буюу энэ чинь жишээ нь МАН-ын Бага хурлаараа энэ 200 гаруй мянган намын гишүүний төлөөлөл болсон Бага хурлаараа энэ чинь орж, сонгогдох эрхээ авдаг шүү дээ. Түүнээс биш зүгээр хэн дуртай нь энэ 200 гаруй мянган намын гишүүн энэ 126 дээр нэр дэвшээд явчихдаггүй. Тэр чинь төлөөллийн байгууллагаараа бас л орж шалгуур хангаж, тэндээ өрсөлдөж, нэр дэвшиж ингэж явж байна гэдэг чинь бол бас л энэ 800 хүний гарын үсэг байтугай л асуудал явагдаж байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд микрофоныг өгөх үү.

Ц.Сандаг-Очир: Шалгуур тавьж байгаа нь өөрөө бас сонгуулийг будилаантуулахгүй байх, Улс төрийн намаас нэр дэвшигчийн хувьд бол намынхаа дотоод дүрэм, журамд заасны дагуу нэр дэвших эрхээ аваад ингээд явчхаж байгаа. Гэтэл бие дааж нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн хувьд бол энэ тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулж байгаа нь хүн болгон шүүхийн өмнө тэгш байна гэдэг энэ зарчмыг нь алдагдуулж байна гэж, ингэж л гомдол гаргагч, өргөдөл гаргагч үзээд байгаа юм.

Тийм учраас би хэлсэн. Цаашдаа бол бас Үндсэн хуулийн цэцийг хүлээж авлаа гэхэд, бие даан нэр дэвшигч нарт ямар ч шалгуургүй нэр дэвших бололцоо

боломж үүснэ гэж ингэж ойлгож болохгүй. Энэ 801-ээс доошгүй гэдэг энэ шалгуур квот босгыг багасгаж болох юм.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд 1 минут нэмээд өгье.

Ц.Сандаг-Очир: Тэр сонгуулийн хорооны тэр маягтыг хянаж, нягталж үзэж байгаа тэр журмаар зохицуулагдаж байгаа харилцааг цаашдаа хуульчилж илүү тодорхой нарийн болгож өгөх шаардлагатай юм байна л гэж хувь гишүүнийхээ хувьд үзэж байгаа юм. Тэрнээс огт шалгуургүй болгоно гэсэн ойлголт биш шүү. Цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа гэхэд бол.

Д.Цогтбаатар: 1 л юу байгаа шүү дээ. Бат-Амгалан гишүүнд ахиад 1 минут. Дахиж сунгахгүй шүү.

Э.Бат-Амгалан: Ойлголоо. Ер нь яах вэ энэ чинь 2016, 2020, 2024 онуудад гээд яг энэ Сонгуулийн хуулиар чинь нэлээд олон бие даагч нар нэр дэвшээд, тэгээд энэ шалгуураа хангаж чадаагүйгээр бас хасагдсан ийм тохиолдлууд байгаа шүү дээ. Тоо баримт, статистик бол байгаа л байх. Тэгээд энэ хүмүүсийн эрхийг тэгээд хэрвээ энэ зүгээр Их Хурал хүлээж аваад, хуульд өөрчлөлт ороод асуудал болоод явлаа гэхэд энэ хүмүүсийн эрхийг эргээд сэргээх ч юм уу, ямар ийм боломж бололцоо байгаа юм. Энэ тал дээр ер нь Цэц дээр яг яригдсан юмнууд байгаа юу.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд.

Ц.Сандаг-Очир: Цэцийн дүгнэлт дээр цэцийн шийдвэр гарсан өдрөөсөө хойш л хэрэгжинэ. Эргэж буцаж үйлчлэхгүй гэдгийг бас тодорхой заасан байгаа. Ер нь бол 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчээс 3-ыг, 2020 оны сонгуульд 14-ийг, 2024 оны сонгуульд 4 нэр дэвшигчийг яг ийм үндэслэлээр бас нэр дэвшихээс нь түдгэлзүүлж, бүртгэж авахгүй байсан асуудлууд гар гэж байсан юм байна лээ. Тийм учраас энэ нэр дэвших эрхээ хязгаарлуулж байсан сонгогдох эрхээ эдэлж чадаагүй хүмүүсийн зүгээс Цэцэд ийм гомдол гаргасан гэж ингэж үзэж байгаа.

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүнд микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Цэцийн энэ дүгнэлтийг би бол хүлээж авах нь зүйтэй гэж бодож байгаа. Цэц бол энэ удаагийн дүгнэлтээр гарахдаа нэлээн хэдэн юмыг бас шалгасан байна лээ. Дүгнэлт дээр ч гэсэн нэлээн тодорхой, маш тодорхой бичсэн байгаа.

801-ийг хэт өндөр гэдгийг бол бас бусад улс орнуудын туршлагатай харьцуулж гаргасан тоо статистикууд бол нэлээн тодорхой байгаа.

2 дугаарт гэвэл бас яг энэ бие даан нэр дэвшигч дээр тавьж байгаа шалгуур чинь өөрөө бусад улс төрийн намаас нэр дэвшиж байгаа хүмүүстэй ижил тэнцүү, ойролцоо байх ёстой. Хэрвээ ялгаатай шалгуур тавьж байгаа бол тэр нь өөрөө үндэслэл бүхий байх ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр хэдийгээр яах вэ, 801-ийг бид нар 1990 оноос хойш дандаа 801 гэдэг энэ хуулийг хэрэгжүүлж эхэлсэн ч

гэсэндээ энэ нь өөрөө бас тодорхой хууль зүйн шалгууруудыг хангахгүй байна гэдэг нь бол цэцийн дүгнэлтээр нэгэнт тогтоогдсон.

Тийм учраас энийг Улсын Их Хурал бол хүлээж авах ёстой гэж бодож байна. Хүлээж авах нь бол үндэслэлтэй гэж харж байгаа. 2 дугаарт гэвэл харин үүнийгээ дагалдуулаад хуульд бол зайлшгүй өөрчлөлт оруулж, нэмэлт, өөрчлөлт бол өргөн баригдах ёстой. 801-ийн босгыг бас манайх өөрсдийнхөө нөхцөл байдалд тодруулж, шалгах ёстой. Ялангуяа хэрвээ бүсчилсэн журмаар цаашид энэ сонгууль болно гэвэл хэд байх юм. Нөгөө тойргийн хэмжээнээс, сонгогчийн хэмжээнээс хамаарах гээд хамаарах гээд байгаа учраас энэ зарчмыг бид нар маш сайн тодорхой тоо заана гэхээс илүү би бол зарчим заах ёстой болов уу гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар бас эргэж нэлээн сайн харах ёстой.

2 дугаарт тэр процессын хувьд эргэж, та бие даан нэр дэвших шалгуурыг та тодорхой хэмжээгээр хангахгүй байна. Энэ, энэ шалгуурыг хангахгүй байна. Эргээд та тэд хоногийн дотор энэ шалгуурыг хангаад ирээч гэдэг бас эргэж энэ алдаа залруулах процесс огт энэ хуульд байхгүй байгаа гээд ийм асуудлууд байгаа учраас би бол энийг бас бусад гишүүдийг ч гэсэндээ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж аваасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Баасанжаргал гишүүнтэй санал 1 байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бол гарын үсэг ер нь цуглуулж байж, бие дааж нэр дэвших эрх, мандатаа олж авах ёстой гэдэг шаардлагыг бол буруутгаагүй байгаад байгаа юм. Энэ 801 гэдэг чинь хүн амтайгаа харьцуулахад, сонгогчийн тоотойгоо харьцуулахад дэлхийн ардчилсан энэ бусад улс орнуудтай харьцуулахад арай өндөр байна шүү гэдэг л нэг ийм зүйлийг хэлсэн байгаа юм.

2 дугаарт бол энэ хуульд нэг ийм тодорхойгүй заалт байна. Гарын үсгээ 21 хоногийн хугацаанд 801 хүнийг цуглуулна. Ингээд гарын үсгээ хянуулах энэ 7 хоногийн хугацаанд энэ гарын үсэг цуглуулах ажил маань үргэлжлэх юм уу, үгүй юү гэдэг нь хуульд тодорхой бус байна гэж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд байгаад байгаа юм. Ийм ч учраас ийм тодорхой бус заалтыг дур зорог, үзэмжээр тайлбарлаж, ялгамжтай байдлаар сонгуулийн байгууллага хэрэглэх боломжтой байна шүү гэдгийг хэлж өгсөн байгаа юм. Ер нь Үндсэн хуулийн цэцээс сүүлийн үед гаргасан 2 дахь энэ цэцийн дүгнэлтэд хүний үндсэн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах ёстой шүү. Тэр үндэслэл нь өөрөө их тодорхой байх ёстой шүү. Тэр хуулийг хэрэглэхэд дур зорго, үзэмж ялгамжтай байдал, тэгш эрхийн зарчмыг нугалах ийм боломж олгохгүй байх ёстой шүү гэдэг ийм анхааруулга, сануулгыг их тийм тооцоо судалгаа үндэслэлтэйгээр Улсын Их Хуралд болон Засгийн газар, бусад байгууллагад 2 дахь удаагаа би энэ шийдвэрээрээ дамжуулж өгч байна гэж ойлгож, энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хүндэтгэлтэй хандаж, хүлээж аваад, тэгээд хүлээж авсны дараа Байнгын хорооноосоо бас ажлын хэсэг гаргаад, ер нь бол энэ ажлын хэсгийн ажиллах хувилбар, томьёолол, судалгаа үндэслэлүүдийг бол Үндсэн хуулийн цэц өөрөө энэ шийдвэртээ их тодорхой хийгээд өгчихсөн юм байна. Тэгэхээр энэ шийдвэрийн үндэслэл хэсэгт заасан зүйлүүдийг нь суулгаад манай Сандаг-Очир гишүүн ч гэсэн хэлж байна. Боломжтой юм гэдгийгээ бол итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хууль тогтоогчийн хувьд бол илэрхийлж байгаа. Тийм

учраас хүлээгээд аваад, холбогдох өөрчлөлтөө хийгээд явъя гэсэн ийм саналтай байна.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зөв гэж үзэж байгаа. Ер нь бид нар иргэний эрхийг хаах, боох ийм захиргааны шинжтэй ийм олон юмнаас татгалзах нь зүйтэй. Тэгэхээр манай Цэц бол их зөв шийдвэр гаргаж, тэр иргэн ч гэсэн бас их зөв өргөдөл өгсөн юм байна гэж ойлгож байна. Дэмжиж байгаа. Хувь заяаны егөөдлөөр би чинь бас 1 удаа 801 хүний гарын үсэг цуглуулсан түүхтэй юм. Тэгээд энэ их шүү. Бас их төвөгтэй. Тэгээд яах вэ, ингээд л нэг цаас тавиад л, иргэд рүү зарлаад л, таньдаг мэддэг хүнээ явуулаад л, баахан амьтан авчраад. Тэгээд юунд санаа зовдог юм гэхээр үгүй ээ, нөгөөдхийг маань хасаад 801-ээс доошоо оруулаад хаячихдаг юм биш байгаа гэж хүртэл бодогддог юм. Тийм учраас энэ босгох нь их өндөр юм шиг байна лээ. Энийг багасгах хэрэгтэй.

Дахиад энд энэ ардчилсан нийгэмд энэ бие даагчийг хаахгүй байх 1 сайн зүйл байгаа. Тэр бол энэ намууд чинь нам биш болчихсон тохиолдолд бол тэгвэл эвлэлдэн нэгдэх эрхийг маань жишээ нь тан дээр таарахгүй байх л даа. Намын дарга чинь хусаад хаячихвал бие даахаас өөр аргагүй. Өөр намаас дэвшилтэй биш дээ гэдэг иймэрхүү нөхцөлүүд ийм хувь хүний хувьд эрхийг нь ингээд хамгаалсан юм энэ их зөв зүйтэй юм байна гэж бодсон.

Харин нэг муу юм их ажиглагдсан. 2 ч сонгуульд би ажиглаж байна. Захиалгат бие даагчид байдаг. Тэд нар хасагдана гэж угаасаа байдаггүй. Бүр харин бийлэгжүү загнадаг. Бараг намтай эн тэнцүү шахуу сурталчилгаа хийдэг. Самбар энэ тэр бол алдаг шүү дээ. Яах вэ энэ ташрамд хэлж байгаа юм. Би ер нь саяын манай Баасанжаргал гишүүн, Энхбаяр гишүүнтэй санал нэг байна. Хэдүүлээ энэ нийгмээ нэг жаахан ингэхгүй бол биш дээ биш. Тэгээд нөгөө зовлон үзсэн чавганц гэдэг шиг ядаж байхад би бас бие даагч байсан байх юм. Тэгээд дэмжээд өгөөрэй манай гишүүд энэ дээр. Тэгээд босгыг нь буулгачихъя.

Д.Цогтбаатар: Би нэг товчхон үг хэлчихье. Би бас энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг дэмжиж байгаа. Сая Алтанхуяг гишүүний хэлдэг зовлонг би бас яг уг нь өөрөө үзсэн хүн. Тэгэхдээ би энийг бүр тэгэх тусмаа дэмжих ёстой гэж бодож байгаа. 2020 онд манай дүүрэг дээр яг Д.Цогтбаатар гэдэг хүнийг дэвшүүлээд, тэгээд тэр ёстой ямар ч асуудалгүйгээр тэр цаанаас нь мөнгө цаасыг нь босгоод, тэр 800 хэдэн хүний гарын үсгийг нь цуглуулаад, тэгээд тэр хүн маш олон санал авдаг юм байна лээ. Яг тэр юугаараа. Тэр чинь хүн андуураад Д.Цогтбаатар гэхээр тийшээ зөндөө санал явчихдаг юм байна лээ. Тэгэхээр гэсэн ч би амьдрал дээр бол яг ийм юм гардаг гэсэн ч энэ босгыг бол буулгах нь зөв. Би яагаад тэгж үзэж байна гэхээр нээрээ энэ Үндсэн хуулийн цэцийнхээ үндэслэлтэй мундаг хандсан байна. Юу гэвэл Энэтхэгийн босго нь тэрбум 400 сая хүнтэй орны босго нь 10 хүн байгаа байхгүй юу. Их Британийнх 10 хүн. Тэгэхээр ийм том орнууд ийм бага босготой байж байхад, бид нар 800 хэдэн хүний босго тавьчхаад сууж байна гэдэг бол нээрээ энэ олон улсын жишгээ харахад, ардчилсан орнуудын жишгээ харахад бол арай өндөр байна. Арай ч биш хамаагүй өндөр байна гэсэн үг.

2-т энэ дээр би нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Энэ 801 гэдэг тоо яах вэ нөгөө нам байгуулахад 801 хүний гарын үсэг авч байгаа шүү дээ. Тэгээд нөгөө

тийм 1992 он. Тэгээд тэр баримжаа сэтгэл зүйд нь ингээд үлдчихсэн яваад байгаа юм болов уу гэж бодож байгаа юм. Гэхдээ үнэхээр энд тэгж болохгүй. Яагаад гэвэл нам байгуулна гэдэг бол үндэсний хэмжээнд тэр нам 126 хүн дэвшүүлж болох субъект буюу этгээдийг байгуулах тооны хэмжээнд хувь хүн нэрээ дэвшүүлэх шалгуурыг аваачиж тавина гэдэг чинь бол жинхэнэ логикийн маш уялдаагүй юм байна. Тийм учраас энийг бол буулгах нь зөв гэж бодож байна. Зүгээр яах вэ, буулгахад харин түрүүн Бат-Амгалан гишүүн асууж байна лээ. Энд яг ингээд буулга гээд яг заачихсан ч юм алга гээд. Яг үнэн тэр тогтоох хэсэг дээр байхгүй байгаа ч гэсэн үүний ерөөсөө үзэл баримтлал тэр чигтээ энэ их байна шүү. Буулгах нь зөв гэж байгаа юм байна лээ.

2-т 1 зүйлийг би харин бодож байгаа юм. Цаашдаа Их Хурал дээр боловсруулахад энийг манайхан бодолцоно биз. Хуулийн төсөл хэрэв боловсруулаад явбал. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр би бол ингэж бодсон. Сонгуулийн ерөнхий хороо тухайн жилдээ сонгуульд оролцох намуудын нөгөө гишүүн дэвшүүлэх бага хурлууд нь байгаа шүү дээ. Өөр өөрийнх нь. Хамгийн бага гишүүдтэй Бага хуралтай намын нэр дэвших босгоор нь тэр тоог нь тэр жилдээ л тогтоогоод өгчихье. Яагаад гэвэл тэгэхгүй бол, жишээлбэл, босохгүй болгочих юм бол намаас нэр дэвшиж байгаа гишүүдийг ялгаварлан гадуурхах юм байна лээ. Бид нар чинь, яагаад гэвэл нөгөө санал авч байгаа шүү дээ. Бас Бага хурлаасаа санал авч байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө хүмүүс ямар ч саналгүй болчихлоор энэ босгын асуудал нээрээ гарч болзошгүй юм байна лээ. Тэгэхээр би зүгээр гэхдээ цаашдаа хууль боловсруулахдаа яах вэ. Миний бол 1 хувилбар энэ байгаа юм. Тэгээд өөрсдөө бодож байгаад эсвэл энэ Британи эд нар шиг ч бүр багасгачихдаг юм уу. Тэгээд гаргана биз дээ гэж бодож байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Ингээд Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.2-т Байнгын хороо цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахтай холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хуулийг хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах гэж заасны дагуу санал хураалт явуулъя. Ингээд 4 санал байж байгаа.

1 дүгээр санал нь. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 69,2 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа

хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

3 дахь санал. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

За энийг яг үнэн тэр үг үсгийнхээ юуг нэг шалгаарай томъёоллоо.

4 дэх санал. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Энэ цэцийн дүгнэлт дээрээ өөрөө энэ яг миний урд одоо байж байна. “Бие даан нэр дэвшүүлэгч нь” гээд явчихсан байж байна. Тийм байна. Цэцийн дүгнэлт дээрээ тэгээд ороод ирчихсэн байж байгаа юм байна. Ингээд 4 дэх саналаар би сая санал хураалгачихсан. Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Номинчимэг гишүүн танилцуулчих уу. Номинчимэг гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

13.21 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ